

**ОЮУ ТОЛГОЙН ДАЛД УУРХАЙН БҮТЭЭН
БАЙГУУЛАЛТ,
САНХҮҮЖИЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ ХХК
ТУРКОЙС ХИЛЛ РЕСУРСЕС ЛИМИТЕД
ТИ ЭЙЧ АР ОЮУ ТОЛГОЙ ЛТД
ОЮУ ТОЛГОЙ НИДЕРЛАНД БИ ВИ
РИО ТИНТО ИНТЕРНЭШНЛ ХОЛДИНГС ЛИМИТЕД
БОЛОН
ОЮУ ТОЛГОЙ ХХК хооронд
2015 ОНЫ 5 ДУГААР САРЫН 18**

**OYU TOLGOI UNDERGROUND MINE
DEVELOPMENT AND FINANCING PLAN**

Among
**The Government of Mongolia
Erdenes Oyu Tolgoi LLC
Turquoise Hill Resources Limited
THR Oyu Tolgoi Ltd
Oyu Tolgoi Netherlands BV
Rio Tinto International Holdings Limited**
And
Oyu Tolgoi LLC
May 18th, 2015

<p>ОЮУ ТОЛГОЙН ДАЛД УУРХАЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</p> <p>Оюу Толгойн Далд Уурхайн Бүтээн Байгуулалт, Санхүүжилтийн энэхүү төлөвлөгөөг (цаашид “Төлөвлөгөө” гэх) 2015 оны 5 дугаар сарын 18-ны өдөр</p> <p>Монгол Улсын Засгийн Газар;</p> <p>Эрдэнэс Оюу Толгой ХХК (“ЭОТ”) (цаашид Монгол Улсын Засгийн Газартай хамтад нь “Монголын тал” гэх);</p> <p>БОЛОН</p> <p>Туркойс Хилл Ресурсес Лимитед, Ти Эйч Ар Оюу Толгой Лтд болон Оюу Толгой Нидерланд Би Ви, (цаашид хамтад нь “Туркойс Хилл” гэх) болон Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед (цаашид “Рио Тинто” гэх);</p> <p>БОЛОН</p> <p>Оюу Толгой ХХК (цаашид “ОТ ХХК” гэх), (цаашид хамтад нь “Талууд” гэх)-ийн хооронд байгуулав.</p> <p>ҮНДЭСЛЭЛ:</p> <p>(А) Талууд болон тэдгээрийн хамааралтай этгээдүүдийн хооронд 2009 оны 10 дугаар сарын 6-ны өдөр Хөрөнгө оруулалтын гэрээг (“ХөОГ”), ОТ ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хооронд 2011 оны 6 дугаар сарын 8-ны өдөр Нэмэлт Өөрчлөлт Оруулж Дахин Тодотгосон Хувь Нийлүүлэгчдийн гэрээг (“НӨОДТХНГ”) (2009</p>	<p>OYU TOLGOI UNDERGROUND MINE DEVELOPMENT AND FINANCING PLAN</p> <p>This Oyu Tolgoi Underground Mine Development and Financing Plan (this “Plan”) is made this 18th day of May 2015</p> <p>AMONG:</p> <p>Government of Mongolia;</p> <p>Erdenes Oyu Tolgoi LLC (“EOT”) (together with the Government of Mongolia, the “Mongolian Party”);</p> <p>AND</p> <p>Turquoise Hill Resources Limited, THR Oyu Tolgoi Ltd and Oyu Tolgoi Netherlands B.V., (together “TRQ”) and Rio Tinto International Holdings Limited (“Rio Tinto”);</p> <p>AND</p> <p>Oyu Tolgoi LLC (“OT LLC”), All referred to collectively as the “Parties”.</p> <p>WHEREAS:</p> <p>A. The Parties and their relevant affiliates have entered into the Investment Agreement (“IA”) dated 6 October 2009 and the Amended and Restated Shareholders Agreement (“ARSHA”) dated 8 June 2011 (which amended and restated the Shareholders Agreement dated 6 October 2009) among the shareholders of OT LLC;</p>
--	---

<p>оны 10 дугаар сарын 6-ны өдөр байгуулсан Хувь нийлүүлэгчдийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж дахин тодотгосон) тус тус байгуулсан;</p> <p>(Б) ХөОГ болон НӨОДТХНГ-нд заасны дагуу, ОТ ХХК нь Монгол Улсын Өмнөговь аймагт байрлах Оюу Толгой төслийн бүтээн байгуулалт, ашиглалтын үйл ажиллагааг эрхлэн явуулж байгаа;</p> <p>(В) ЭОТ нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 348 дугаар тогтоол, Эрдэнэс МГЛ ХХК (одоо Эрдэнэс Монгол ХХК)-ийн ТУЗ-ийн 2011 оны 28 дугаар тогтоолын дагуу ОТ ХХК дахь Монгол Улсын Засгийн газрын хувь эзэмшлийг шилжүүлэн авч, холбогдох эрхийг хэрэгжүүлэх этгээдээр томилогдсон;</p> <p>зэргийг үндэслэн, энэхүү Төлөвлөгөөнд заасан харилцан хүлээх үүргүүдийг Талууд дараах байдлаар тохиролцов. Үүнд:</p>	<p>B. Pursuant to the IA and the ARSHA, OT LLC is developing and operating the Oyu Tolgoi Project in the South Gobi region of Mongolia;</p> <p>C. EOT was designated to hold and exercise the rights in the Mongolian Government shares in OT LLC under Mongolian Government Resolution 348 of 2011 and Erdenes MGL LLC (now Erdenes Mongol LLC) Board Resolution 28 of 2011; and</p> <p>NOW, THEREFORE, in considerations of the mutual covenants hereinafter set forth, the Parties agree as follows:</p>
<p>1. НЭР ТОМЬЁНЫ ТОДОРХОЙЛОЛТ</p> <p>Энэхүү Төлөвлөгөөнд хэрэглэгдсэн нэр томьёог тухайн зүйл заалтад өөрөөр заагаагүй тохиолдолд дор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>“НӨОДТХНГ” –ийн тодорхойлолтыг энэхүү Төлөвлөгөөний Үндэслэл хэсэгт зааснаар ойлгоно.</p> <p>“Аудитын хороо” гэж НӨОДТХНГ-ний 5.9 заалтын дагуу “Оюу Толгой” компанийн ТУЗ-өөс байгуулсан Аудит, Санхүү, Хангамжийн хороог хэлнэ.</p> <p>“Хөрөнгө оруулалтын зардал” –ын тодорхойлолтыг НӨОДТХНГ-нд заасан утгаар ойлгоно.</p>	<p>1. DEFINITIONS</p> <p>Capitalized terms used in this Plan shall have the following meanings, unless the context requires otherwise:</p> <p>“ARSHA” is defined in the recitals of this Plan.</p> <p>“Audit Committee” means the Audit, Finance and Procurement Committee of the Oyu Tolgoi Board established by the Oyu Tolgoi Board in accordance with clause 5.9 of the ARSHA.</p> <p>“Capital Costs” has the meaning ascribed to it in the ARSHA.</p>

<p>“Далд уурхайн үе шатны Хөрөнгө оруулалтын зардал” гэж Далд уурхайн үе шатны бүтээн байгуулалттай холбоотой Компаниас гарч байгаа, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн зарчмын дагуу хөрөнгө оруулалтын зардал гэж тодорхойлогдох бүх зардал, өртөг, шимтгэлийг хэлэх бөгөөд үүнд компаниас гарах урсгал хөрөнгө оруулалт зэрэг бусад зардлыг оруулахгүй.</p> <p>“ЭОТ” гэж Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийг хэлнэ.</p> <p>“Техник эдийн засгийн үндэслэл” буюу “ТЭЗҮ” -ийг энэхүү Төлөвлөгөөний 4.2-т тодорхойлноор ойлгоно.</p> <p>“Хөрөнгө оруулалтын гэрээ” буюу ХөОГ-г энэхүү Төлөвлөгөөний Үндэслэл хэсэгт заасан утгаар ойлгоно.</p> <p>“Менежментийн төлбөр” -ийг НӨОДТХНГ-ний 7.4-т заасан утгаар ойлгоно.</p> <p>“Металс Дэйли” гэж Платс (Макграв Хилл Файнаншл Инк-ийн салбар нэгж)-аас Металс Дэйли нэрээр өдөр тутам эрхлэн гаргадаг тайланг, эсвэл Платс-аас уг тайлангийн оронд гаргасан аливаа хэвлэлийг, эсвэл хэзээ нэгэн цагт уг тайлан хэвлэгдэхээ больсон тохиолдолд Талуудын харилцан тохиролцсоны үндсэн дээр сонгон авсан, энэхүү Төлөвлөгөөний 6.3-т заасан зах зээлийн үнийн индексүүдээр тайлан гаргадаг өөр тайланг ойлгоно.</p> <p>“Монголын тал” гэж Монгол Улсын Засгийн газар болон ЭОТ-г хэлнэ.</p> <p>“Ил Уурхайн Үе Шат” гэж Төлөвлөгөөний 4(a)-д тодорхойлсныг хэлнэ.</p> <p>“Оюу Толгой компанийн ТУЗ” гэж ОТ ХХК-ийн Төлөөлөн</p>	<p>“Capital Costs of the Underground Stage” means all costs, expenses and charges incurred by the Company in relation to construction of the Underground Stage that are recognized as capital costs in accordance with internationally accepted accounting principles, but does not include other Capital Costs, including without limitation sustaining capital, incurred by the Company.</p> <p>“EOT” means Erdenes Oyu Tolgoi LLC.</p> <p>“Feasibility Study” has the meaning ascribed to it in Section 4.2.</p> <p>“IA” has the meaning ascribed to it in the recitals of this Plan.</p> <p>“Management Services Payment” has the meaning ascribed to it in clause 7.4 of the ARSHA.</p> <p>“Metals Daily” means the publication known as Metals Daily and published daily by Platts (a division of McGraw-Hill Financial Inc), or any replacement of that publication published by Platts or if that publication ceases to be published at any time, another publication as agreed between the Parties which reports the market price indices referred to in Section 6.3.</p> <p>“Mongolian Party” means the Government of Mongolia and EOT.</p> <p>“Open Pit Stage” has the meaning ascribed to it in Section 4.1(a)</p> <p>“Oyu Tolgoi Board” means the Board of Directors of OT LLC.</p>
---	---

удирдах зөвлөлийг хэлнэ.

“**ОТ ХХК**” гэж Оюу Толгой ХХК-ийг хэлнэ.

“**Оюу Толгой төсөл**” гэж ХӨОГ-ний 16.34-т тодорхойлсоныг хэлнэ.

“**Бүтээгдэхүүн**” гэдгийг ХӨОГ-нд заасан утгаар нь ойлгоно.

“**Рио Тинто**” гэж Рио Тинто ПиЭлСи, Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед болон тэдгээрийн хамааралтай этгээдүүдийг хэлнэ.

“**Төслийн санхүүжилтийн баталгааны шимтгэл**” гэж Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед, Рио Тинто Саут Ийст Азия Лимитед болон Туркойс Хилл-ийн 3 хооронд 2012 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр байгуулсан Санамж бичигт заасны дагуу Далд уурхайн Төслийн санхүүжилт авахад Рио Тинтогоос төслийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэх баталгаа гаргаж дэмжлэг үзүүлэхтэй холбогдуулан Рио Тинто-д төлөх шимтгэлийг хэлнэ.

“**Хувьцаа эзэмшигчид**” гэж НӨОДТХНГ-ний 25 дугаар зүйлд заасан “Хувь нийлүүлэгч” гэсэн тодотголтой адил утгатай байна.

“**Туркойс Хилл**” гэж Туркойс Хилл Ресурсес Лимитед, Ти Эйч Ар Оюу Толгой Лтд болон Оюу Толгой Нидерланд Би Ви-г хамтад нь хэлнэ.

“**Далд уурхайн ТЭЗҮ**” гэж Далд уурхайн үе шатны бүтээн байгуулалтын Техник эдийн засгийн үндэслэлийг хэлнэ.

“**OT LLC**” means Oyu Tolgoi LLC.

“**Oyu Tolgoi Project**” has the meaning ascribed to it in clause 16.34 of the IA.

“**Products**” has the meaning ascribed to it in the IA.

“**Rio Tinto**” means Rio Tinto plc and Rio Tinto International Holdings Limited and each of their affiliates.

“**Project Finance Guarantee Charge**” means the fee payable to Rio Tinto in consideration of Rio Tinto providing the Completion Support Undertaking to support the provision of project financing for the Underground Stage as described in the Memorandum of Agreement dated 7 April 2012 between Rio Tinto International Holdings Limited, Rio Tinto South East Asia Limited and TRQ.

“**Shareholders**” has the meaning ascribed to it in clause 25 of the ARSHA.

“**TRQ**” means, collectively, Turquoise Hill Resources Limited, THR Oyu Tolgoi Ltd and Oyu Tolgoi Netherlands BV.

“**UG FS**” means the Feasibility Study for the development of the Underground Stage.

<p>“Далд уурхайн Төслийн санхүүжилт” гэж Төлөвлөгөөний 4.7(a)-д тодорхойлсныг хэлнэ.</p> <p>“Далд уурхайн Үе шаг” гэж Төлөвлөгөөний 4(b)-д тодорхойлсныг хэлнэ.</p> <p>“2010 оны ТЭЗҮ” гэж Оюу Толгой төсөлд зориулан 2010 онд боловсруулсан ТЭЗҮ-г хэлнэ.</p>	<p>“UG Project Finance” has the meaning ascribed to it in Section 4.8(a).</p> <p>“Underground Stage” has the meaning ascribed to it in Section 4.1(b)</p> <p>“2010 Feasibility Study” means the Feasibility Study prepared in 2010 in respect of the Oyu Tolgoi Project.</p>
<p>2. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</p> <p>2.1 Талууд хоорондоо үүсээд буй асуудлууд дээр ойлголцон, нэгдсэн шийдвэрт хүрч, ОТ ХХК-ийн хэрэгжүүлж буй Оюу Толгой төслийн бүтээн байгуулалтыг гүйцээх ажлыг шуурхайлах хүсэл эрмэлзэлтэй байна.</p> <p>2.2 ОТ ХХК нь Монгол Улсын хууль тогтоомж болон ХөОГ-нд заасны дагуу Монгол Улсын холбогдох бүх хууль тогтоомжийг мөрдөж ажиллах үүрэгтэй ба ингэхдээ ХөОГ-нд заасан эрх зүйн болон татварын орчныг тогтворжуулах тухай заалтуудыг баримтална. Талууд:</p> <p>(a) ХөОГ болон НӨОДТХНГ-ний заалт, нөхцөлүүдийг дагаж мөрдөхөө нотолж байна;</p> <p>(б) Далд уурхайн ТЭЗҮ-д тусгагдсаны дагуу Оюу Толгой төслийн эдийн засгийн үр ашгийн хуваарилалт нь 2010 оны ТЭЗҮ-д тооцсон тооцоололтой нийцэж байгаа ба үүнтэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газар нь Оюутолгой төсөл хэрэгжих хугацаанд төслийн нийт үр ашгийн 53 гаруй хувийг татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ногдол ашиг хэлбэрээр авахыг цохон тэмдэглэж байна.</p> <p>2.3 ОТ ХХК нь Оюу Толгой компанийн ТУЗ-ийн удирдлага дор,</p>	<p>2. GENERAL</p> <p>2.1 The Parties desire to clarify and resolve issues that have arisen between them in order that they can proceed expeditiously with the full development of the Oyu Tolgoi Project through OT LLC.</p> <p>2.2 OT LLC is obligated by Mongolian law, and by the IA, to comply with all applicable laws of Mongolia, subject to the legal and tax stabilization provisions of the IA. The Parties:</p> <p>(a) confirm their commitment to the terms and conditions of the IA and the ARSHA; and</p> <p>(b) note that, based on the assumptions on which the UG FS was prepared, the share of economic benefits of the Oyu Tolgoi Project are in line with those referred to in the 2010 Feasibility Study, whereby the Government of Mongolia will receive over 53% of the total value of the Oyu Tolgoi Project over the life of the Oyu Tolgoi Project in the form of taxes, royalties and dividends.</p> <p>2.3 The Parties acknowledge and confirm that OT LLC will be</p>

<p>Монгол Улсын хууль тогтоомж, ХөОГ, НӨОДТХНГ-ний дагуу, санхүү, эдийн засгийн зарчмуудыг удирдлага болгон, ашиг олох зорилго бүхий аж ахуй нэгжийн хэлбэрээр ажиллана гэдгийг Талууд тэмдэглэж, бататгав.</p> <p>2.4 ОТ ХХК-ийн засаглал, санхүүжилт, санхүүгийн үйл ажиллагааг хянаж удирдах зорилгоор:</p> <p>(a) НӨОДТХНГ-нд заасны дагуу ОТ ХХК-ийн данс бүртгэлийг олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт болон НӨОДТХНГ-ний 8.3-т заасан нягтлан бодох бүртгэлийн стандарт шаардлагын дагуу аудитын олон улсын стандарт, туршлагад нийцүүлэн жилд нэгээс доошгүй удаа Оюу Толгой компанийн ТУЗ-өөс Монгол Улсын хуулийн дагуу томилсон хөндлөнгийн аудитын Монгол компаниар шалгуулна;</p> <p>(б) Жил тутам хийгдэх эдгээр аудитаас гадна Далд уурхайн үе шатны хөрөнгө оруулалтын зардлын хяналт, тайланг тусгайлан хянах зорилгоор Оюу Толгой компанийн ТУЗ шаардлагатай тохиолдолд нэмэлт аудит хийлгэх хүсэлт гаргаж болно;</p> <p>(в) ОТ ХХК-ийн үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах зорилгоор засаглалын дараах арга хэмжээнүүдийг шинээр нэвтрүүлсэн. Үүнд:</p> <p>(i) Аудитын хороо зарим (худалдан авалт, хөрөнгө оруулалтын зарцуулалт, санхүүжилт зэрэг) үйл ажиллагаанд нарийвчилсан хяналт тавьж ажилласан.</p> <p>(ii) Үйл ажиллагааны явцад хяналт тавих сар тутмын хурлуудыг (хөрөнгө оруулалтын зарцуулалт зэрэг) зохион байгуулдаг болсон.</p>	<p>operated as a commercial business through the Oyu Tolgoi Board, guided by economic and financial principles, and in accordance with Mongolian law, the IA and the ARSHA.</p> <p>2.4 In order to manage and monitor the financial performance, funding and governance of OT LLC</p> <p>(a) the accounts of OT LLC shall be audited at least once a year as required by the ARSHA against international accounting standards and having regard to the accounting standards requirements of clause 8.3 of the ARSHA, and in accordance with international auditing standards and practices, by an independent Mongolian audit firm in accordance with Mongolian laws as appointed by the Oyu Tolgoi Board;</p> <p>(b) in addition to these annual audits, the Oyu Tolgoi Board may request further audits from time to time, specifically to cover controls and reporting of the capital expenditure of the Underground Stage;</p> <p>(c) to improve transparency of OT LLC’s activities, further governance procedures have been implemented including:</p> <p>(i) detailed oversight of activities (including procurement, capital spend and financing) by the Audit Committee; and</p> <p>(ii) monthly operations review meetings (including updates on capital expenditure).</p>
--	--

<p>2.5 Аудитын хорооны даргаар зохих шалгуурт нийцэх Оюу Толгой компанийн ТУЗ-ийн гишүүнийг Монголын талаас нэр дэвшүүлэн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл ажиллуулна.</p>	<p>2.5 Until 31 December 2020, the chairman of the Audit Committee shall be a suitably qualified member of the Oyu Tolgoi Board nominated by the Mongolian Party.</p>
<p>3. ДОТООДЫН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ</p> <p>3.1 Далд уурхайн үе шатны бүтээн байгуулалт, үйл ажиллагааны зардал, Монгол Улсын Засгийн газарт төлөх төлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор Монгол улсын нутаг дэвсгэрт зарцуулагдах зардлын тооцоо, бүтээн байгуулалтын ажлын болон зардлын төлөвлөгөөг дараах хүснэгтэд тойм байдлаар үзүүлэв. Энэхүү хүснэгтэд танилцуулсан тоо баримтууд нь төслийн цар хүрээ, зардал, график төлөвлөгөө, техникийн үзүүлэлтүүд, зах зээлийн нөхцөл байдал зэрэг Далд уурхайн ТЭЗҮ-д тусгагдсан өгөгдлүүд дээр үндэслэн тооцоологдсон болно. Монгол улсын дотоодод зарцуулах зардлыг Оюу Толгой компанийн хуримтлуулсан туршлага, бүтээн байгуулалтын ажлын төлөвлөгөө зэрэгт тулгуурлан тооцож энд үзүүлсэн байгаа ба зохих чанарын шаардлагыг хангах, зардлын хувьд хэмнэлттэй дотоодын ханган нийлүүлэгчдээс хамаарна гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Бүх тоог цаг хугацааны энэ мөчлөг дэх нөхцөл байдал дээр үндэслэж тооцсон бөгөөд тэдгээрт баталгаа гаргахгүй тул бодит гүйцэтгэлээр эдгээр тооцооллоос зөрүүтэй дүн гарч болно.</p> <p>3.2 ХөОГ-ний 4 дүгээр бүлэгт заасны дагуу ОТ ХХК нь Өмнөговь аймаг, Ханбогд сум, Манлай сум, Баян-Овоо сум, Даланзадгад сумдтай Хамтын ажиллагааны гэрээ байгуулахыг Талууд бүрэн дэмжиж байна. Уг Хамтын ажиллагааны гэрээний дагуу ОТ ХХК жил бүр 5 сая хүртэлх ам.долларыг Өмнөговийн бүс нутгийн хөгжилд зориулан олгоно.</p>	<p>3. IMPACT ON DOMESTIC ECONOMY</p> <p>3.1 The table below sets forth the indicative development and spending plan, including estimates of funds that will be spent within Mongolia to fund operating costs, Underground Stage construction and payments to the Government of Mongolia. The table is based on a number of assumptions relating to scope, costs, schedule, technical aspects and market conditions on which the projections contained in the UG FS are based. Estimated domestic Mongolian expenditures are based on historical Oyu Tolgoi experience and current development plans, however are subject to suitable quality, cost-effective, domestic suppliers. All amounts are estimates as of the current point in time and are not guaranteed; actual amounts will undoubtedly vary from these estimates.</p> <p>3.2 Consistent with chapter 4 of the IA, the Parties are fully supportive of OT LLC entering into the Community Cooperation Agreement with Umnogovi Aimag, Khanbogd Soum, Manlai Soum, Bayan-Ovoo Soum and Dalanzadgad Soum, whereby OT LLC will contribute up to USD 5 million per year for expenditure on South Gobi (Umnogovi) regional development as provided in that Agreement.</p>

Тэрбум ам боллар	1-р жил	2-р жил	3-р жил	4-р жил	5-р жил	6-р жил	7-р жил	Нийт
Хөрөнгө оруулалтын зардал								
Далд уурхайн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын зардал	0,3	1,1	1,0	1,1	0,7	0,5	0,1	4,7
Урсгал хөрөнгө оруулалтын зардал	0,1	0,1	0,0	0,1	0,4	0,4	0,5	1,5
Хөрөнгө оруулалтын зардалд ногдуулах НӨАТ ба бусад татвар	0,0	0,1	0,1	0,1	0,1	0,1	0,1	0,6
Хөрөнгө оруулалтын нийт зардал	0,4	1,2	1,1	1,3	1,2	1,0	0,6	6,8
Дотоодод шууд зарцуулахаар тооцсон зардал								
Монгол Улс дахь үйл ажиллагааны зардал	0,6	0,6	0,6	0,6	0,6	0,6	0,7	4,3
Монгол Улс дахь хөрөнгө оруулалтын зардал	0,2	0,5	0,4	0,5	0,4	0,4	0,2	2,5
Монгол Улсын Засгийн газарт шууд төлөх төлбөр	0,3	0,3	0,3	0,3	0,3	0,3	0,4	2,2
Монгол улсад шууд зарцуулах нийт дүн	1,1	1,3	1,2	1,3	1,4	1,3	1,3	9,0

3.3 OT ХХК нь Монгол Улсын иргэн, хуулийн этгээд тэр дундаа Өмнөговь аймагт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд давуу эрх олгож тэдний нийлүүлж буй бараа үйлчилгээг болон Монгол улсад үйлдвэрлэсэн тоног төхөөрөмж, түүхий эд, бараа материал, сэлбэг хэрэгсэл зэргийг цаг хугацаа, зардал, тоо хэмжээ, чанарын хувьд өрсөлдөхүйц байх нөхцөлтэйгөөр, тэргүүн ээлжинд худалдаж авна. Оюутолгой төсөлд шаардлагатай ачаа тээврийн үйлчилгээг авахдаа дотоодын ханган нийлүүлэгчдэд давуу тал олгоно. OT ХХК-ийн энэхүү үүргийн биелэлтэд Аудитын хороо хяналт тавьж ажиллана.

3.4 Энэхүү Төлөвлөгөөг баталснаас 30 хоногийн дотор, Таван Толгойн цахилгаан станцаас цахилгаан эрчим хүч худалдаж авахтай холбогдуулан, OT ХХК-ийн хүлээсэн үүрэгт дэмжлэг үзүүлэх үүднээс Төлбөрийн чадамж сайжруулах механизмын төсөөллийг Таван Толгойн цахилгаан станцын Төсөл хэрэгжүүлэх нэгжид бэлтгэн өгөхөөр, OT ХХК болон Туркойс Хилл компаниуд тогтов. Төлбөрийн чадамж сайжруулах механизмын төсөөллийг Туркойс Хилл компанийн зүгээс өгөхөөр тооцож байгаа ба Туркойс Хилл бусад холбогдох этгээдээс эцсийн байдлаар дэмжлэг үзүүлэх эсэх, түүний хэмжээг Таван Толгойн

In USD billions	Year 1	Year 2	Year 3	Year 4	Year 5	Year 6	Year 7	Total
Capital								
Underground Development capital	0.3	1.1	1.0	1.1	0.7	0.5	0.1	4.7
Sustaining capital	0.1	0.1	0.0	0.1	0.4	0.4	0.5	1.5
WAT and Duties on capital	0.0	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.6
Total Capital	0.4	1.2	1.1	1.3	1.2	1.0	0.6	6.8
Estimated Direct Mongolian Spend								
Domestic operating cost expenditure	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.7	4.5
Domestic capital cost expenditure	0.2	0.5	0.4	0.5	0.4	0.4	0.2	2.5
Direct payment to Government of Mongolia	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.4	2.2
Total Estimated Direct Mongolian Spend	1.1	1.3	1.2	1.3	1.4	1.3	1.3	9.0

3.3 OT LLC shall, on a priority basis, purchase and utilize services supplied by Mongolian citizens and/or legal entities, and equipment, raw materials, materials and spare parts manufactured in Mongolia, with preference to businesses operating in the Umnogovi Aimag, to the extent such services and materials are available on a competitive time, cost, quantity and quality basis, and shall give preference to Mongolian suppliers of freight and transportation services required for the Oyu Tolgoi Project. OT LLC's performance against this obligation shall be monitored by the Audit Committee.

3.4 Within 30 days of the execution of this Plan, OT LLC and TRQ agree to prepare and submit to the Project Implementation Unit of the Tavan Tolgoi Power Plant Project working assumptions for a possible credit enhancement mechanism to support OT LLC's obligations under a potential power purchase arrangement from Tavan Tolgoi Power Plant Project. The working assumptions for the credit enhancement mechanism is currently contemplated to be made available at TRQ level, however the extent of the possible support from TRQ or any related entity will be subject to negotiation with the prospective investors and lenders of the Tavan Tolgoi Power Plant Project.

<p>цахилгаан станцын төслийн хөрөнгө оруулагч, зээлдүүлэгч нартай хийх яриа хэлэлцээнээс хамааран шийднэ.</p> <p>3.5 Зэс хайлуулах үйлдвэрийг Монгол Улсад барьж байгуулах, ажиллуулах эдийн засгийн боломжийн талаарх судалгааны тайланг ОТ ХХК нь 2016 оны 9 дүгээр сараас өмнө боловсруулна. Энэхүү судалгааг гаргаснаар ОТ ХХК-ийг ХөОГ-ний 3.19-ийн дагуу хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэнд тооцох бөгөөд энэ нь ОТ ХХК-ийн ХөОГ-ний дагуу хүлээсэн бусад эрх, үүрэгт нөлөөлөхгүй.</p>	<p>3.5 OT LLC will prepare a research report by September 2016 on the economic viability of constructing and operating a copper smelter in Mongolia to process concentrate from the Oyu Tolgoi Project into metal. This study will finally and fully satisfy the 5 obligations of Oyu Tolgoi LLC as set out in clause 3.19 of the IA and does not affect any other rights and obligations of Oyu Tolgoi LLC under the IA.</p>
<p>4. ДАЛД УУРХАЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ</p> <p>ХөОГ-ний 9.6-д заасны дагуу Оюу Толгой төслийг үе шаттайгаар хэрэгжүүлж болно. Энэхүү Төлөвлөгөөний зорилгын хүрээнд:</p> <p>(а) Ил уурхайн Үе шат гэж Оюу Толгойн ил уурхай, баяжуулах үйлдвэр болон холбогдох дэд бүтцийг барьж байгуулах, ашиглалтад хүлээлгэн өгөх, мөн далд уурхайн босоо амны нэвтрэлтийн урьдчилсан ажлууд болон далд уурхайн хэвтээ малталт нэвтрэлтийн урьдчилсан ажлуудыг ойлгоно;</p> <p>(б) Далд уурхайн Үе шат гэж Далд уурхайн ТЭЗҮ-д заасны дагуу Хойд Хюго ордыг ашиглах далд уурхайн 1 дүгээр давхрын бүтээн байгуулалтын ажил, далд уурхайгаас олборлох хүдрийг боловсруулах зорилгоор баяжуулах үйлдвэр болон холбогдох дэд бүтцэд хийх өөрчлөлтийг ойлгоно. Эргэлзээ үүсгэхгүй байх үүднээс, Хойд Хюго ордын 1 дүгээр давхраас бусад далд уурхайн аливаа бүтээн байгуулалтын ажлыг Далд уурхайн Үе шатанд оруулж тооцохгүй.</p> <p>4.2 Техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) гэж уул уурхайн төслийн санхүүгийн үр ашгийг тогтоох зорилгоор ашигт малтмалын ордын геологи, инженерийн шийдэл, хууль эрх зүй,</p>	<p>4. UNDERGROUND MINE CONSTRUCTION</p> <p>4.1 In accordance with clause 9.6 of the IA, the development of the Oyu Tolgoi Project may occur in stages. For the purpose of this Plan:</p> <p>(a) Open Pit Stage means the development and commissioning of the Oyu Tolgoi open pit mine, concentrator and associated infrastructure, preliminary shaft sinking works and lateral development for the underground; and</p> <p>(b) Underground Stage means the construction of Hugo North Lift 1 underground mine and modification of the concentrator and infrastructure to handle underground ore, as described in the UG FS. For the avoidance of doubt, the Underground Stage does not include any future underground developments other than Hugo North Lift 1.</p> <p>4.2 A Feasibility Study (FS) is a comprehensive study that calculates in detail the geological-engineering solutions, legal, operational, economic, social, environmental and other factors of a mineral deposit</p>

үйл ажиллагаа, эдийн засаг, нийгэм, байгаль орчны болон бусад холбогдох хүчин зүйлсийг нарийвчлан тооцоолсон цогц судалгааг ойлгоно. Техник, эдийн засгийн үндэслэл нь тодорхойгүй, магадалшгүй хүчин зүйлсээс хамаарч өөрчлөгдөж болзошгүй төсөөллүүдэд тулгуурласан, бодит гүйцэтгэл нь ТЭЗҮ-д зааснаас өөр гарч болох тооцооллуудаас бүрдэх бөгөөд эрхзүйн хувьд заавал мөрдөх баримт бичиг биш болохыг Талууд хүлээн зөвшөөрөв.

4.3 Ил уурхайн Үе шаттай холбогдох зардлууд 2010 оны ТЭЗҮ-д зааснаас зөрсөн асуудлыг бүрэн ойлгох үүднээс удаа дараа хийсэн шалгалт, аудит, түүний дотор Монгол Улсын Засгийн газрын гурван сайдын хамтарсан тушаалын дагуу гүйцэтгэсэн шалгалтын дараагаар Талууд дараах ойлголцолд хүрэв. Үүнд:

(а) Ил уурхайн Үе шатны нийт зардал нь батлагдсан хөтөлбөр, төсвийн дагуу зарцуулагдсан бөгөөд тэдгээрийг ОТ ХХК-ийн санхүүгийн тайлангуудад үнэн зөвөөр тусгаж эдгээр тайлангуудаа Сангийн яаманд мэдүүлсэн;

(б) Зардлын зөрүү нь шаардлагатай хэмжээнд тайлбарлагдсан бөгөөд Ил уурхайн Үе шатны зардалтай холбоотой сөрөг үр дагавар бүхий дүгнэлт, Талуудын хооронд үл ойлголцол байхгүй.

4.4 Монгол Улсын Сангийн яам нь энэхүү Төлөвлөгөөг байгуулснаас ажлын 5 (таван) хоногийн дотор ОТ ХХК-ийн мэдүүлсэн 2010, 2011, 2012, 2013, 2014 онуудын санхүүгийн тайлангуудыг хүлээж авч баталгаажуулна.

4.5 Энэхүү Төлөвлөгөөний 4.4-д заасны дагуу ОТ ХХК-ийн санхүүгийн тайлангуудыг Монгол Улсын Сангийн яам хүлээн авснаас хойш ажлын 2 хоногийн дотор Монгол Улсын Татварын

for the purposes of determining the financial viability of a mining project. The Parties acknowledge and agree that Feasibility Studies contain estimates only and are not binding, are based on assumptions that are subject to uncertainties and contingencies that may prove not to be correct, and actual results may vary from the estimates in the Feasibility Study.

4.3 Following a number of reviews and audits, including an audit initiated by three ministers of the Government of Mongolia to understand cost variances on Open Pit Stage against the 2010 Feasibility Study, the Parties agree that:

(a) the total costs of Open Pit Stage have been incurred in accordance with approved programmes and budgets, and are accurately reflected in the financial statements of OT LLC as submitted to the Ministry of Finance; and

(b) the cost variances have been explained adequately, and there are no adverse conclusions and no outstanding issues between the Parties in relation to the costs of Open Pit Stage.

4.4 Within 5 (five) working days after the date of this Plan, the Ministry of Finance will approve OT LLC's financial statements, as filed, for the years 2010, 2011, 2012, 2013 and 2014.

4.5 Within 2 (two) working days after approval of OT LLC's financial statements by the Ministry of Finance in accordance with clause 4.4, the General Department of Taxation of Mongolia will:

Ерөнхий газар нь:

- (a) ХөОГ-ний 2.33-т заасан хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлтийн ХөОГ-ний 2.26-ын дагуу тооцсон хуримтлагдсан дүн нь 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 646'260'000 ам.доллараос багагүй байгааг баталгаажуулна;
- (б) ХөОГ-ний 2.26-ын дагуу тооцсон ОТ ХХК-ийн шилжүүлэн тооцох алдагдлын дүн нь 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 256'580'000 ам.доллараос багагүй байгааг баталгаажуулна.

4.6 ОТ ХХК нь менежментийн төлбөр болон бусад Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадуур үзүүлсэн үйлчилгээнд ногдуулах НӨАТ-ыг (Монгол Улсын холбогдох төрийн эрх бүхий байгууллага аль эсвэл шүүх нь НӨАТ-ын тухай хуулийн оршин суугч бус этгээдээс суутгах өөрөө тайлагнах татварын тухай заалт нь Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадуур үзүүлсэн үйлчилгээнд хамаарахгүй тухай шийдвэр гаргах аль эсвэл тогтоох) хүртэл үргэлжлүүлэн төлсөн хэвээр байх болно.

